



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Премиум Нэксус ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("Хурал")-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дох заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дох заалт, 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- Хурлыг 2024 оны 04-р сарын 25-ны өдрийн 11:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 2 давхарт биечлэн болон <https://hural.cumongol.mn> веб хаягаар Zoom платформ ашиглан цахим хэлбэрээр хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
- Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл ("ТҮЗ")-ийн гаргасан дүгнэлтийг батлах;
 - Компанийн 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТҮЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах.
- Хурлын зарыг 2024 оны 03-р сарын 20-ны өдөр, давтан зарыг 2024 оны 04-р сарын 04-ний өдөр тус тус өдөр тутмын сонин, Компани болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
- Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэр болон Хуралтай холбоотой бусад материалыг тусгасан Хурлын материалыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04-р сарын 08-ны өдрөөр тогтсугай.
- Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах боломжийг 2024 оны 04-р сарын 08-ны өдрөөс хувьцаа эзэмшигчдэд олгосугай. Үүнд:
 - Хурлыг зарлан хуралдуулах тухай ТҮЗ-ийн тогтоол;
 - Хурлын зар;
 - Хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл;
 - Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
 - Хурлын саналын хуудасны загвар;
 - Хуралд цахимаар санал өгөх заавар.
- Хурлын даргаар Гүйцэтгэх захирал А.Ганхуягийг томилсугай.

8. Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр дор дурдсан нэр бүхий ажилтнуудыг томилсугай. Үүнд:
 - (i) Г.Чинзориг, Гүйцэтгэх захирлын орлогч (дарга);
 - (ii) С.Дашдорж, Мерчандайзинг, Ханган нийлүүлэлтийн газрын захирал;
 - (iii) Д.Бүдханд, Конвииенс дэлгүүрийн бизнесийн Санхүүгийн газрын захирал;
 - (iv) Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.
9. Хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Б.Эрдэнэцэцэг, Голомт Капитал УЦК-ийн Харилцагчийн үйлчилгээний ахлах (дарга);
 - (ii) Н.Халиунгоо, Голомт Капитал УЦК ХХК-ийн Брокер;
 - (iii) А.Намуун, Голомт Капитал УЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч.
10. Хурлын материалыг 2024 оны 03-р сарын 20-ны өдөр брокерын компаниуд болох Голомт Капитал УЦК ХХК болон Апекс Капитал УЦК ХХК-д хүргүүлсүгэй.
11. Хуралд санал өгөх хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2024 оны 04-р сарын 08-ны өдрөөс 04-р сарын 25-ны өдрийн хооронд <https://hural.cumongol.mn> веб хаягаар хийж, санал өгөх линк, нууц кодыг хувьцаа эзэмшигчдийн гар утсанд илгээсний үндсэн дээр дээрх өдруүдэд цахимаар хулээн авахаар шийдвэрлэсүгэй.
12. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисс үүрэг болгосугай.
13. Хурлын мэдэгдлийг 2024 оны 03-р сарын 19-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (А.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ДАРГА:



ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Ганхуяг

А.ГАНХУЯГ

Ганболд

А.ГАНБОЛД

Бат-Эрдэнэ

Г.БАТ-ЭРДЭНЭ

З.Уянга

З.УЯНГА

Чинзориг

Г.ЧИНЗОРИГ

Б.Бат-Эрдэнэ

Б.БАТ-ЭРДЭНЭ

О.Эрдэнэчимэг

Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

Ганзориг

В.ГАНЗОРИГ